



ДУНДГОВЬ АЙМАГ
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/02

Рашаант

Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог
баталж, шинэчлэн тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”-ын 2.1, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан орон тоо, цалингийн санд багтаан албан хаагчдынхаа цалин хөлсийг зохих журмын дагуу тогтоож олгохыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Оюунханд), нягтлан бодогч (Б.Будгэрэл) нарт зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг нийт албан хаагчдад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ГАСРАНДОРЖ



4828230101

Сумын Засаг даргын даргын 2023 оны 01-дүгээр сарын 02-ны
өдрийн А/02 дүгээр захирамжийн хавсралт



ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

д/д	Албан тушаал	Орон тоо
1	Засаг дарга	1
2	Засаг даргын орлогч	1
3	Засаг дарын Тамгын газрын дарга	1
4	Санхүүгийн албаны дарга	1
5	Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн	1
6	Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн	1
7	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
8	Багийн Засаг дарга	6
9	Төрийн сангийн мэргэжилтэн	1
10	Нягтлан бодогч	2
11	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
12	Нярав	1
13	Жолооч	1
14	Үйлчлэгч	1
15	Жижүүр, сантехникч	1
16	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
17	Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
	НИЙТ	23